



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 17/146

Улаанбаатар хот

Бруцеллэз өвчнөөс урьдчилан
сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/276 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/950 дугаар захирамж, Нийслэлийн мал эмнэлгийн газрын даргын А/76 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд шуурхай зохион байгуулж, хяналт тавьж, ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

2. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад тус дүүргийн өвчинд мэдрэмтгий 765 тугал, 2883 хурга, 1517 ишгийг бүрэн хамруулж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЕФ ТРЕЙД" ХХК (А.Цэрэндагва)-д, вакцинжуулалт хийгдэх товлосон хугацаанд малчдад зар хүргэж, мал, амьтнаа бэлэн байлгах ажлыг зохион байгуулж ажиллахыг хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 494,050 (Дөрвөн зуун ерэн дөрвөн мянга тавь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Заавар зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200429

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 09 сарын 10 -ны өдрийн 11/196 дугаар
захирамжийн хавсралт



**БРУЦЕЛЛЁЗ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТ
БОЛОН ХЯНАЛТЫН АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

1.Шатахуун, зүү тариур, халдвар хамгаалал, холбоо, зарлан мэдээллийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун А-92	л	165	2410	397,650.00
2	Шатахуун А-92 (вакцины татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалтад)	л	40	2410	96,400.00
ДҮН					494,050